ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Татварын улсын байцаагчийн цамц зангианы хослол, хилийн бүсэд ажилладаг албан хаагчдын ажлын хувцасны иж бүрдэл хувцас нь шинэлэг техник технологиор, чанартай материалаар хийгдсэн, дараах үндсэн шаардлагыг хангасан байна. Дүрэмт хувцсыг 2 багц болгон шалгаруулж, дараахь тоо, хэмжээгээр худалдан авна.
Үүнд:
Багц 1: **Татварын улсын байцаагчдын ажлын цамц, зангианы 800 ширхэг хослол нийлүүлэх;**
Багц 2: **Хилийн бүсэд ажилладаг албан хаагчдын ажлын хувцасны иж бүрдэл 40 ширхэг нийлүүлэх;**

Хоёр. Зориулалт

Цамц зангиаг татварын улсын байцаагч албан ажилдаа өдөр тутам өмсөнө.

Хилийн бүсэд ажиллаж буй татварын байцаагч нь татвар хураамж авах, гадаа талбайд бүртгэл хийж /тээврийн хэрэгслийг бүртгэх/ гадаа ажиллах үед өвлийн ажлын хувцас, хавар намрын хүрэм болон зуны ажлын хувцсыг өмсөнө.

Багц 1: **Татварын улсын байцаагчдын ажлын цамц, зангианы хослол**

Ашиглах материал

Бүтээгдэхүүний нэр	**Зориулалт**	**Даавууны холио (Зөвшөөрөгдөх зөрүү ±3.0%)**
Бөс даавуу	Богино ханцуйтай цамц	CM50xCM50/140x80, easy care

1.1. Үндсэн материал

Ангилал	**Хэмжээ**	**Зориулалт**
Наалт	Олон улсын чанарын шаардлага хангасан	Зах, эмжээрийг бэхлэх
	Олон улсын чанарын шаардлага хангасан	Тууз бэхлэх
	Олон улсын чанарын шаардлага хангасан	Даавууны урд хэсгийг бэхлэх
Товч	11мм	Товчийг хуванцар материалаар, товчны захаар тойруулан “Монголын татварын алба” гэсэн бичигтэй байна.
Шошго	Олон улсын чанарын шаардлага хангасан	Чанарын шошго, байгууллагын шошго, размерийн шошго, угаалгын заавар
Оруулга	Олон улсын чанарын шаардлага хангасан	Пластик хүзүүний тууз /боодлын материал/

Зах тогтоогч	Олон улсын чанарын шаардлага хангасан	Пластик бэхлэх
Хавчаар	Олон улсын чанарын шаардлага хангасан	Пластик хатуулгыг захны дотор барьж оёсон байх
Хатуулгатай цаас	Олон улсын чанарын шаардлага хангасан	Боодлын зориулалттай
Гялгар цаас	Олон улсын чанарын шаардлага хангасан	Боодлын зориулалттай

2.Үйлдвэрлэл болон боловсруулалт

2.1 Зах нь доод талдаа товчтой байна.

2.2 Захны доод өндөр 3см, нугаламын өндөр 4.6см, эрмэгийн өндөр 7.2см байна.

2.3Энгэрийн чиглэлийг эрэгтэй, эмэгтэй ангилалаар хийнэ.

2.3 Энгэрийн бланкыг 2 чиглэлтэй оёдолтой, оёдол хооронын зай 2,2см байна.

2.4 Урд талын зүүн, баруун энгэртээ тагтай халаастай, товчтой, дундаа нугалаатай байна.

2.4 Сорочкан цамцны доод хэсгийг 0,3мм-ээр нугалаж оёно.

2.5 Хажуу талыг 0,5мм-ээр битүү оёдлоор оёно

2.5 Ханцуйн тэмдэг-

2.5.1 Нийтэд нь хиймэл торгон материалаар оёсон ялгах тэмдэг байна.

2.5.2 Арын хэсэгт зузаан наалт хийсэн байна.

2.5.3 Өнгө нь татварын тогтоосон өнгө байна.

2.5.4 Хэмжээг татварын байгууллагаас тогтоосон хэмжээ байна.

2.6 Сорочкан цамцны зүүн ханцуй дээр Монголын татварын албаны лого оёно.

ЛОГОНЫ ЗУРАГ

2.7 Сорочкан цамцны захны дотор талын нарийн хэсгийг цагаан цэнхэр өнгийн материалаар оёно.

2.8 Зүүн энгэрийн халаасны дээр “Монголын татварын алба” гэсэн үгийг /Хөх/ өнгийн утсаар хатгамал хийнэ.

2.9 Мөрний хойно далны хэсгийг тэгш тайрч дээд талын бөс даавууг хоёр хэсэг болгоно.

2.10 Зангиа нь хар хөх өнгийн, “Монголын татварын алба” гэсэн шар өнгийн хамтгамал бичээстэй байна.

3. Тэмдэглэгээ

Цамцны дотор талын ташаа хэсэгт тендерт оролцож байгаа байгууллагын нэр, материалын чанар, цамцны размерийг харуулсан шошгыг дотор захны гол хэсэгт хэвлэнэ.

(Размерийн шошгоны жишээ/ 42 М(Эрэгтэй размер),41(хүзүүний тойрог)-83(Гарын урт))

(Богино ханцуйтай цамц) 42 М 41-49
(Богино ханцуйтай цамц) 38 М 37-40

Style : Windsorcollar. poly button. Flappatch pocket
Color : Kentucky Blue
Material: Polyester 87%. Polyurethane 13%



<u>Ханцуйн тэмдэг</u>

Багц 2: **Хилийн бүсэд ажилладаг албан хаагчдын ажлын хувцасны иж бүрдэл**

1.1.Зуны ажлын хувцасны иж бүрдэл

Техникийн тодорхойлолтын хураангуй:

Цамц, өмд, саравчтай малгай гэсэн 3 хос байна.

Зуны ажлын хувцас цайвар цэнхэр өнгийн цамцтай, хар хөх өнгийн өмдтэй, хар хөх өнгийн саравчтай малгайтай. /Гэрээ байгуулах үед өнгөө дахин тохирно. /Зун

өмсөхөд зохимжтой, тоос шороо татдаггүй, хөлөргөдөггүй, амархан хир болохгүй, агаарын солилцоо сайн нэвтэрдэг, ганддаггүй материалыг сонгоно.

- Цамц нь цайвар цэнхэр өнгийн, хоёр энгэрт далд тагтай халаастай, урт ханцуйтай, хормой нь ташаан хэсэгтээ резинэн сойлт бүхий манжеттай. Зүүн энгэртээ "Монголын татварын алба" гэсэн хатгамал бичлэгтэй, зүүн ханцуйнд Монголын татварын албаны логотой байна.
- Өмд нь шулуун загвартай, 2 ташаанд ташуу хэлбэрийн далд халаастай, халаасны урт 190 мм, өргөн 170 мм, хажуу гуяны харалдаа байрлах халаас нь тагтай, хөндийрүүлэгчтэй, тагны дунд хэсэгт кнопон товчтой, урд талдаа цахилгаантай, резинтэй байна.
- Малгай нь, хар хөх өнгийн саравчтай, урд хэсэгтээ "Монголын татварын алба" логотой байна.
- Эталон загварыг хийж ирүүлнэ.

1.2. Хавар, намрын хувцасны иж бүрдэл

Техникийн тодорхойлолтын хураангуй:

- Дан хүрэм, хар хөх өнгийн, нимгэн синтефон ширмэл салдаг дотортой хүрэмний зүүн энгэрт "Монголын татварын алба" гэдэг үгийг, зүүн ханцуйнд татварын байгууллагын эмблемийг шар өнгийн утсаар хатгаж оёсон, зүүн баруун хажуу талдаа далд халаастай, хажуу ташаанд кнопон товчоор даруулсан богино сойлттой, залгаа мөртэй, ханцуй нь манжеттай, манжетний өргөнийг тохируулагч кнопон товчтой, өгзөг хаасан урттай байна. Бага зэргийн саравчтай, сойлт уяатай, салдаг юүдэнтэй байна.
- Эталон загварыг хийж ирүүлнэ.
- Даавууны холио нь 65 % хөвөн даавуу, 35% полиэстер байна. Даавууны холио (Зөвшөөрөгдөх зөрүү ±3.0%)
- Нарны гэрэлд, хөлсөнд, нойтон, усанд, угаалганд будгийн тогтворжилтын стандарт шаардлагыг хангаж, ганддаггүй, будаг гардаггүй байна.

1.3. Өвлийн ажлын хувцасны иж бүрдэл

Техникийн тодорхойлолтын хураангуй:

Өвлийн ажлын хувцас нь хар хөх өнгөтэй, хүрэм өмд, сүлжмэл даавуун малгайны хослол байна.

Өвлийн ажлын хувцасны загварыг гаргахдаа дараахь ерөнхий шаардлагыг хангаж, худалдан авах ажиллагаанд оролцоно.

Өвлийн ажлын хувцасны даавууны орц холио: хөвөн 55%, полиэстр 45% байна.

- Салдаг зузаан угаалга, арчилгаа даах чадвартай дотортой хүрэм, өмдний хослол байна.
- Хар өнгийн хиймэл үстэй салдаг захтай,
- Хүрэм нь салдаг малгайтай, хоёр энгэрт далд тагтай халаастай. "Монголын татварын алба" гэсэн хатгамал бичлэгтэй, зүүн ханцуйнд Монголын татварын албаны логотой, баруун ханцуйны гадна талд тагтай жижиг халаастай, бүсэлхийгээр салхи нэвтрүүлэхгүй байх далд байрлалтай чангалагч уяатай, ханцуйны дотор талд резинэн манжаттай, гадна талд хэмжээ тааруулагч кнопон товчтой сойлттой байна. Тохой,

суга, болон ар нуруу, өмдний өвдөг хэсгээр хөдөлгөөн чөлөөлөгчтэй байна. Өмдний өгзөг хэсэгт элэгдэлээс хамгаалсан давхарлагатай байна.

- Хүрэмний дотор нь эрүүл мэндийн шаардлага хангасан чанартай материалаар хийгдсэн байна.
- Хослолын өмд нь даавуу гадартай, үслэг зөөлөн хайрдаггүй, гулсамтгай дотортой, нуруувчтай, 2 хажуу талдаа халаастай, хөндийрүүлэгчтэй, тагны дунд хэсэгт кнопон товчтой, өвдөг болон өгзөг давхарлагдсан байна.
- Хүрэм нь малгайтай байна. Малгай нь бага зэргийн саравчтай, хэмжээ тааруулагч сойлготой, малгай нь хиймэл үстэй байна.
- Зүүн энгэрт "Монголын татварын алба" гэсэн хатгамал бичлэгтэй, урд энгэртэй цахилгаан товчтой, түүнийг таглаж оёсон урт хаалттай, хаалт нь кнопон товчтой, урд талын дээд 2 энгэрт далд байрласан цахилгаантай, тагтай халаастай, халаасан дотор талаас наалддаг зангуутай "Монголын татварын алба" лого, гарч ирнэ. 2 хажуу доод талд ил байрласан тагтай халаастай.
- Хослолын кноп, цахилгаан, тоноглолыг гадуур хувцасны зориулалттай, чанартай, үзэмжтэй гүйцэтгэнэ.
- Сүлжмэл даавуун малгай хар хөх өнгөтэй, малгайны урд хэсэгт Монголын татварын албаны логотой байна. Малгай нь хэлбэр алдахгүй, агшиж сунахгүй, бүрзийлт өгдөггүй, чанартай материалаар хийгдсэн байна.
- Эталон загварыг хийж ирүүлнэ.
- Нарны гэрэлд, хөлсөнд, нойтон, усанд, угаалганд будгийн тогтворжилтын стандарт шаардлагыг хангаж, ганддаггүй, будаг гардаггүйбайна.

НИЙТЛЭГ ШААРДЛАГА

3.1. Бүх дүрэмт хувцасны дотор талд нийлүүлэгчийн эмблем бүхий шошго хадсан байна.

3.2. Дүрэмт хувцасны загварыг багц тус бүрээр нь оёж үндсэн болон туслах материалын биет каталогийг эскиз зургийн хамт тендер шалгаруулалтаас өмнө захиалагчид ирүүлнэ.

3.3. Тендерт шалгарсан хувцас болон үндсэн, зарим туслах материалын загварыг захиалагч авч үлдэх бөгөөд энэ нь нийлүүлэх бусад хувцсыг шалгах загвар /эталон/ болно.

3.4. Тендерт ялж, гэрээ байгуулах эрх авсан нийлүүлэгчийн нийлүүлэх дүрэмт хувцас нь зөвхөн эталон загвартай дүйцэхүйц чанар, дизайнтай байна.

3.5. Тендерт оролцогч нь энэхүү тендерийн бүх багцад орж болно. Эсхүл аль нэг багцыг сонгон оролцож болно.

Тусгай заалтууд: Дүрэмт хувцсыг хослолоор нь гялгар уутанд савлаж, гадна талд том үсгээр, тод өнгөөр харагдахуйцаар размер, хүйс зэргийг бичсэн байна. Гялгар баглаа боодол нь тоос

шорооноос хамгаалсан, ус, чийг нэвтрэхгүй, хувцасны хадгалалтын явцад хуучирч муудахгүй байх нөхцлийг хангахаар савласан байна.

Баталгаат хугацаа: 1 жил ба түүнээс дээш байх.

Бусад үйлчилгээ: Баталгаат хугацаанд үйлдвэрлэлийн гэмтэл согогтой болон размерийн алдаатай хувцсыг нийлүүлэгч өөрсдийн зардлаар сольж өгөх буюу солих боломжгүйг шинээр хийж өгнө.

Бараа хүргэх газар: Татварын ерөнхий газрын агуулах

Стандарт: Олон улсын болон Монгол Улсын чанар стандартад нийцэхүйц бүтээгдэхүүн байх.

Татварын улсын байцаагчдын ажлын цамц, зангианы 800 ширхэг хослол нийлүүлэх

Размер /EU/	**34**	**36**	**38**		**40**		**42**		**Нийт дүн**	
Хүйс	эм	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм
Тоо ширхэг	4	35	15	130	45	120	110	120	**264**	**536**
Размер /EU/	**44**		**46**		**48**		**50**			
Хүйс	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм		
Тоо ширхэг	60	80	20	30	12	15	2	2		

Хилийн бүсэд ажилладаг албан хаагчдын ажлын хувцасны иж Бүрдэл 40 ширхэг нийлүүлэх

Размер /EU/	**34**	**36**	**38**		**40**		**42**		**Нийт дүн**	
Хүйс	эм	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм
Тоо ширхэг		1	1	4	3	8	3	6	**15**	**25**
Размер /EU/	**44**		**46**		**48**		**50**			
Хүйс	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм		
Тоо ширхэг	3	5	3	1	1		1			